

СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ОЮУН УХААНЫГ ТӨЛӨШҮҮЛЭХЭД ХӨГЖМИЙН БОЛОВСРОЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Өлзийбаярын Намираа^{1,*},
Одонхүүгийн Мөнхжаргал²

¹ Хөлөнбуйр их сургууль, Боловсрол судлалын тэнхим, Хөлөнбуйр хот, Хятад улс

² Монгол улсын их сургуулийн Ховд дах салбар сургууль, Боловсрол судлал, арга зүйн тэнхим, Ховд аймаг, Монгол улс

* Холбоо барих зохиогч: 359788673@qq.com

Хураангуй: Оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэхэд хөгжмийн боловсролын нөлөөг судлах нь судалгааны шинэ чиглэл болж байна. Энэхүү хөгжмийн боловсролд сурагчдын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг төлөвшүүлэх нь улам бүр чухал байр суурь эзэлсээр байгаа тул сэтгэл хөдлөлийн оюун ухааныг төлөвшүүлэхэд хөгжмийн боловсролын үзүүлж буй нөлөөлүүдийг судлахад судалгааны зорилго оршино.

Энэ өгүүлэлд сэтгэл хөдлөлийн оюун ухаан ба хөгжмийн боловсролын уялдаа холбоог тайлбарласан бөгөөд хөгжмийн боловсрол нь оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэх үр дүнтэй арга бөгөөд сурагчдын сэтгэл зүйн зөв ойлголтыг хөгжүүлж, суралцагчдын бүх талыг хөгжүүлэх ач холбогдолтой, шинэлэг асуудал юм.

Бид энэхүү судалгааны ажлаараа сэтгэл хөдлөлийн оюун ухааныг төлөвшүүлэхэд хөгжмийн боловсролыг ашигласан судалгааны үр дүнгүүдэд анализ, дүн шинжилгээ хийж ажилласан. Эл дүн шинжилгээний үр дүнд хөгжмийн боловсрол нь сэтгэл хөдлөлөө ойлгох, илэрхийлэх, бусдын сэтгэл хөдлөлийг мэдэрч ойлгоход нөлөөлж байна.

Түлхүүр үг: хөгжим, хөгжмийн боловсрол, сэтгэл хөдлөл, сэтгэл хөдлөлийн оюун ухаан

RESEARCH ON THE EFFECT OF MUSIC EDUCATION ON CULTIVATING EMOTIONAL INTELLIGENCE

Namiraa Ulziibayar^{1,*}
Munkhjargal Odonkhuu²

¹ Education School of Hulunbuir University, Khulunbuir city, China

² Khovd Branch School of National University of Mongolia

* Corresponding author: 359788673@qq.com

Abstract: The study of the effects of music education on the development of students emotional intelligence is a new area of research. The purpose of this study is to investigate the effects of music education on the development of emotional intelligence, as the development of students' emotional intelligence is becoming more and more important in this music education.

This article describes the relationship between emotional intelligence and music education, and music education is an effective way to develop students emotional intelligence, and it is a significant and innovative issue for the development of students psychological understanding and all-round development of students.

In this research, we analyzed and analyzed the results of studies using music education to develop emotional intelligence. According to the results of the analysis, music education has an impact on understanding and expressing emotions and feeling and understanding the emotions of others.

Keywords: music, music education, emotions, emotional intelligence

Оршил

Сэтгэл хөдлөлийн оюун ухааныг ихэвчлэн EQ гэж нэрлэдэг бөгөөд генетикийн хүчин зүйлсийн нөлөөнд хязгаарлагддаг IQ-ээс ялгаатай. Тэр нь хүмүүжлээр дамжин бий болсон оюун ухааны нэг төрөл юм. Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь өнөөгийн нийгэмд ажиллах, суралцах амьдралд нөлөөлөх зэрэг олон үр дагавартай байна. Харин хөгжмийн боловсрол нь гоо зүйн шинж чанартай бөгөөд тэр нь өөрийгөө сэтгэл хөдлөлөө мэдрэх, сэтгэл хөдлөлөө зөв удирдах, өөрийгөө урамшуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Үндсэн хэсэг

1. Сэтгэл хөдлөлийн оюун ухаан болон хөгжмийн тухай

1980-аад оноос хойш Америкийн сэтгэл судлалын нийгэмлэг уламжлалт оюун ухааны онолуудад онцгойлон шүүмжлэлтэй хандаж эхэлсэнтэй холбоотой Штернберг¹ амжилтын оюун ухааны онол², Гарднер³ оюун ухааны олон талт

¹ Sternberg

² Success intelligence theory

³ Gardner

онол⁴ зэрэг онолууд шинээр гарч ирсэн. Яловын их сургуулийн Саловри⁵ ба Нью Хэмпирийн их сургуулийн багш Майер⁶ нар зөвхөн танин мэдэхүйн бүтэцтэй уламжлалт оюун ухааныг сэтгэл хөдлөлийн талбарт өргөжүүлсэн бөгөөд 1990 онд тэд сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь оюун ухааны нэг төрөл гэж сэтгэл хөдлөлийн оюун ухааны тухай ойлголтыг албан ёсоор дэвшүүлжээ. Тухайн үед тэд сэтгэл хөдлөлийн оюун ухааныг гурван чадварын бүтэцтэй гэж тодорхойлсон. Үүнд:

Сэтгэл хөдлөлийг үнэн зөв үнэлэх, илэрхийлэх чадвар

Сэтгэл хөдлөлийг зохицуулах чадвар

Амжилтад хүрэх хүсэл эрмэлзэл, хүсэл зоригийг хэрэгжүүлэх үйл явцад сэтгэл хөдлөлийн туршлагыг ашиглах чадвар багтана.

1993 онд Саловри ба Майер нар сэтгэл хөдлөлийн оюун ухааны агуулгыг цаашид гурван зүйлээр тодорхойлсон нь өөрийнхөө сэтгэл хөдлөлийг бусдаас ялгах чадвар, өөрийгөө болон бусдын сэтгэл хөдлөлийг зохицуулах чадвар, сэтгэл хөдлөлийг ашиглан сэтгэхүйг удирдан чиглүүлэх чадвар юм.

1995 онд “Нью-Йорк Таймс” сонины шинжлэх ухааны салбарын сурвалжлагч Даниэль Гоулман “Сэтгэл хөдлөлийн оюун ухаан” гэх бүтээлдээ сэтгэл хөдлөлийн оюун ухааныг таван зүйлээр тодорхойлсон байна.

1. Өөрийгөө танин мэдрэх чадвар

2. Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар

3. Өөрийгөө урамшуулах чадвар

4. Өөрийгөө хянах чадвар

5. Хүний харилцааны ур чадвар юм (Goleman, 1997, 45).

Уламжлалт оюун ухаан нь тухайн хүний бодит амьдрал дахь амжилтыг илэрхийлж чаддаггүйгээс гадна сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь уламжлалт оюун ухааны онол дээр суурилоод оюун ухааны онолын хөгжлийг ихээхэн баяжуулж, оюун ухааны мөн чанарыг ил гаргах шинэ боломжийг олгодог бөгөөд хүмүүст хөгжим болон оюун ухааны хөгжлийн хууль тогтоомжийг судлах шинэ санааг олгожээ (Jiang, 1985).

Хөгжим бол сэтгэл хөдлөлийг шууд илэрхийлэх урлагийн хэлбэр бөгөөд хүний хамгийн түгээмэл, хамгийн эртний, хамгийн ихээр гайхан бишрүүлдэг зүйлийн нэг юм. Хүмүүс хөгжимд сонирхолтой байдаг шалтгаан нь хөгжим нь хүмүүсийн сэтгэл хөдлөлийг агуулдаг. Жишээлбэл, аз жаргалтай, гунигтай, баяр хөөртэй гэх мэт. Хөгжимчид өөрсдийн чиглэл бүрээр тэдгээрийг зохион байгуулалттай, тодорхой хэлбэрээр илэрхийлдэг байна (Jiang, 1985, 53).

Хөгжмийн бүтээлүүд хөгжмийн зохиолчийн дотоод ертөнц, сэтгэлийн хөдлөлийг шууд илэрхийлж, энэ нь сонсогчдод шууд хүрдэг учраас сонсогчийг аз жаргалтай, гунигтай, сэтгэлийн хөөрөлтэй болгодог. Тэр ч байтугай нулимс дуслуулах эсвэл хөөрөн баясуулдаг байна (Zhaolan, 2005, 256-257). Ерөнхийдөө сэтгэл хөдөлгөсөн, тааламжтай хөгжмийн айзам нь илүү хурдан бөгөөд тайван байдаг, гунигтай хөгжмийн айзам нь удааширдаг, гунигтай, сэтгэл хөдөлсөн

⁴ Multiple intelligence theory

⁵ Salovry

⁶ Mayer

хөгжмийн айзам нь илүү хүчтэй байдаг. Тайван, аз жаргалтай хөгжмийн айзам нь илүү сул байдаг. Үүнээс харахад хөгжмийн айзмын өвөрмөц онцлог нь түүний сэтгэл хөдлөлийн илэрхийлэлд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Уэдин (1972)-ийн судалгаанаас харахад тогтвортой, удаан айзам нь ихэвчлэн таагүй байдалтай холбоотой байдаг. Урсам, хурдан айзам нь тааламжтай байдалтай холбоотой байдаг (Wedin, 1972, 241-257).

Судлаач Брунер ба Гордон (1990)-ийн судалгаа ч удаан хөгжимтэй харьцуулахад хурдан хөгжим нь илүү сэтгэл хөдөлгөм тааламжтай байдаг (Bruner, Gordon, 1990, 54) гэсэн судалгааны үр дүнгээ танилцуулсан байдаг ба Габриела, Или нар болон бусад хүмүүс (2006) хурдан хөгжмийн ая нь удаан тэмптэй хөгжмөөс илүү хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж байгааг харуулсан (Pie, Thompson, 2006, 23). БНХАУ-ын судлаач Хуанг Вэйпинг (2007)-ийн хийсэн судалгаагаар аялгуу болон найруулга, төрлөөс үл хамааран хөгжмийн хурд нь их сургуулийн оюутнуудын сэтгэл санаанд хүчтэй нөлөөлдөг. Ихэнх хурдан хөгжим нь таашаал, баяр хөөр гэх мэт эерэг сэтгэл хөдлөлийг бий болгодог. Харин эсрэгээр ихэнх удаан хөгжим нь уйтгар гуниг, гансрал, уур уцаар, уур хилэн зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийг бий болгодог гэжээ. Кай Южиан⁷ мөн ижил төстэй үр дүнг судалж гаргаж ирсэн (Yuejian, Xiaofu, Zhongchunxiao, 2007, 196-198).

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Кээлийн их сургуулийн сэтгэл судлаач Жон Слобода, Патрик Юуслинг нар хөгжим болон хүмүүсийн гэнэтийн сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг холбож судалжээ. Гэнэтийн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх чадвар нь хүний сэтгэл хөдлөлийн үйл ажиллагааны үндэс болдог. Сугалаанд хожсоноор хүний сэтгэл хөдлөл гэнэт өөрчлөгдөж, сэтгэл хөдлөлийн эерэг хариу урвал үүснэ. Хамаатан садан, найз нөхөд нь өвчтэй гэдгийг мэдэхэд бас гайхмаар боловч сэтгэл хөдлөлийн сөрөг хариу үйлдэл болох уйтгар гунигийг бий болгодог. Хүмүүст дээрх хөгжмийн механизм нь гэнэтийн зүйлтэй ижил юм шиг санагддаг. Хүмүүс хөгжим дэх уялдаа холбоог ялгаж чаддаг бөгөөд дараагийн ноотуудыг тодорхойлж чаддаг. Хөгжмийн хэмнэл өөрчлөгдөхөд бидний сэтгэцийн байдал өөрчлөгдөх болно. Бүх хүмүүс сэтгэл хөдлөлийг хэлээр илэрхийлэх ижил дүрэмтэй байдаг бөгөөд хөгжим ч мөн адил байдаг. Сэтгэл зүйч Юслин, Спарта нарын хэдэн зуун хүнийг хамруулсан судалгааны үр дүнгээс харахад, тайвшруулдаг, гүн гүнзгий хөгжим нь хүмүүсийг гунигтай болгодог ба илүү өндөр аялгуу нь хүмүүсийг догдлуулж, эдгээр хоёр нөлөөг хослуулснаар хүний тархи сэтгэл хөдлөлийн гайхалтай үйл ажиллагааг бий болгож чаддаг болохыг харж болно.

2. Хөгжмийн боловсролын сэтгэл хөдлөлийн оюун ухаанд үзүүлэх нөлөө

Хөгжмийн боловсролын зорилго ба даалгаврын тодорхой байдал, үр нөлөө, заах аргын олон талт байдал, сургалтын материалын баялаг хэрэглэгдэхүүн, сургалтын үйл явцад оюутнуудтай харилцах харилцаа зэрэг нь суралцагчдад сэтгэл хөдлөлийн эерэг ойлголт олгодог. Өөрөөр хэлбэл, сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэх хамгийн сайн сонголт бол хөгжмийн боловсрол юм. Энэ нь сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэхэд бүтээлч, бэхжүүлэх үүрэг гүйцэтгэдэг (Weiping, 2007, 90).

⁷ Cai Yuejian

Хятадын сэтгэл судлаачдын нийгэмлэгээс 2006 оны 5-р сард гаргасан зөвлөмжиндөө Мерседес Павличевичийн “Хөгжмийн эмчилгээний онол ба практик үйл ажиллагаа” номыг санал болгосон байдаг. Энэхүү орчин үеийн сэтгэлзүйн эмчилгээний ном нь гадаад дотоодын хөгжмийн багш нарын анхаарлыг татсан бөгөөд түүний оршил хэсэгт “Орчин үеийн хүмүүсийн хувьд хөгжим үргэлж хэлнээс гадуур утга агуулдаг” (Pavlicevic, 2006, 87) гэж дурджээ.

Хөгжмийн боловсролын сэтгэл хөдлөлийн оюун ухаанд үзүүлэх нөлөө авч үзье.

1. Хөгжмийн боловсрол нь өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгоход үзүүлэх нөлөө

Сэтгэл хөдлөлийн оюун ухаанд “өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох” чадвар нь сэтгэл хөдлөлийн оюун ухааны цөм, өөрөөр хэлбэл, өөрийгөө болон сэтгэлзүйн ойлголтыг ойлгох үндсэн чадвар юм. Психоаналистууд үүнийг “төвлөрсөн би” гэж нэрлэдэг. Хөгжмийн боловсрол нь хүмүүсийн янз бүрийн мэдрэмжийг төрүүлснээр хүмүүсийн сэтгэл хөдлөлийн оюун ухааныг төлөвшүүлдэг мэдрэхүйн боловсрол юм. Хөгжмийн боловсрол нь өвөрмөц нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, хүүхдүүд “Би жаахан цэрэг” гэсэн дууны аялгууг сурч мэдсэнээр “бяцхан цэрэг”-ийн эр зориг, хүч чадлыг мэдэрч, хүүхдүүдэд хөгжимд үзүүлсэн хатуу, хүчтэй сэтгэл хөдлөлийг мэдрэхэд нь тусалж, өөрсдийн хатуу, хүчтэй сэтгэл хөдлөлийг таньж чаддаг.

2. Хөгжмийн боловсрол нь сэтгэл хөдлөлөө зөв удирдахад үзүүлэх нөлөө

Хүүхдүүд хөгжим эсвэл ээжийн шивнэн дуулахыг сонсоод чимээгүйхэн унтаж чаддаг бөгөөд хүүхэд эсвэл нялх хүүхдэд зориулсан хөгжмийн дадал нь хүүхдүүдийн сэтгэл хөдлөлийг зөв удирдан чиглүүлэхэд тусалдаг. Төлөвлөгөөтэй, шинжлэх ухааны хөгжмийн боловсрол эзэмшсэн хүүхдүүд илүү сэргэлэн цовоо, тэвчээртэй, сэтгэл хөдлөлөө эзэмдэж чаддаг (Jingjing, 2010, 32-33) болох нь баримтаар нотлогдсон байдаг. Судалгаанаас харахад хүмүүс гунигтай байхдаа хөгжим сонсож, сэтгэлийн хөдлөлөө зохицуулж, удирдаж чаддаг байна. Уртын дуу бол монгол үндэстний бүтээсэн хөгжмийн хэлбэр бөгөөд үндэстний нүүдэлчдийн түүх, соёлыг бэлгэдсэн байдлаар харуулдаг. Үүний зэрэгцээ уртын дуу нь монголын нүүдэлчин соёлын амьдралын чухал хэсэг юм. Нэрт монгол эрдэмтэн Уланжие хээрийн судалгааны бичлэгээ ашиглан монгол уртын дуу хүмүүст баяр баясгалан, таашаал авчирдаг болохыг нотолж судалгаа хийсэн. Энд онцгойлон дурдвал, Өвөр Монгол дахь зарим монгол сэтгэл засалчид удаан хугацааны туршлагаар дамжин уртын дуугаар сэтгэл гутралтай өвчтөнүүдийг эмчлэн, сэтгэл засал хийж байна. Хөгжмийн эмчилгээний салбарт уянгалаг, гунигтай уртын дуугаар сэтгэл гутралтай өвчтөнүүдийг эмчилсэн жишээ олон байдаг.

3. Хөгжмийн боловсролын өөрийгөө идэвхжүүлэхэд үзүүлэх нөлөө

Хөгжим нь сэтгэл хөдлөлийг голчлон хоёр хэлбэрээр өдөөдөг байна. Үүний нэг нь ерөнхий төлөв дэх гоо зүйн туршлага буюу сэтгэл хөдлөлийн өдөөлт юм. Гоо сайхны туршлагаас бий болсон эерэг сэтгэл хөдлөл

хүмүүсийг эрүүл, идэвхтэй байлгадаг. Энэ нь ой тогтоолт, төсөөлөл, сэтгэлгээ гэх мэт танин мэдэхүйн болон сэтгэлзүйн үйл ажиллагаагаар хүмүүсийг идэвхжүүлдэг. Энэ бол тайвширсан хөгжим сэтгэл хөдлөлийг өдөөж чаддаг шалтгаан юм. Хоёрдугаарт, дээд зэргийн туршлага, хүсэл тэмүүлэл бүхий туршлага юм. Энэ нь зөвхөн сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийн тоон тэлэлт төдийгүй чанарын өөрчлөлт юм. Энэ нь гоо зүйн туршлагаас таашаал авсаар байгаа боловч голчлон дээд сэтгэл хөдлөлийн хандлага, зан чанарын мэдрэмжийг төрүүлдэг. Өндөр, гунигтай хөгжим нь хүмүүст сэтгэлийн асар их урам зоригтой туршлагыг бий болгож, өөрийгөө хөгжүүлэх хүчтэй сэдэл өгдөг. Хүмүүсийг хүчтэй эерэг сэтгэл хөдлөлтэй болгоно. Хөгжим нь сэтгэл хөдлөлийг өдөөх, хүмүүсийн сэтгэл хөдлөлийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг тул дэлхийн бүх улс хөгжмийн боловсролыг сэтгэл хөдлөлийн боловсролын гол цөм гэж үздэг.

4. Хөгжмийн боловсрол нь бусдын сэтгэл хөдлөлийг ойлгоход үзүүлэх нөлөө

Бусдын сэтгэл хөдлөлийг таньж, бүх хүмүүстэй харьцах нь сэтгэл хөдлөлийн оюун ухааны хамгийн дээд чадвар юм. Хөгжим нь хөгжмийн зохиолчийн сэтгэл хөдлөлийг сонсголоор дамжуулан ойлгох эсвэл дууг импровизаци хийх бөгөөд ингэснээр сэтгэл хөдлөлийн ойлголтыг илэрхийлэх, суралцагчид бусдын дотоод илэрхийллийг сонсож чаддаг. Маш сайн дуучин бол хөгжмийн зохиолчийн хөгжим бүтээх сэтгэлийн мэдрэмжийг ойлгож, сэтгэл хөдлөлийн мэдрэмжийг хөгжмийн тоглолтод уялдуулж чаддаг бөгөөд энэ нь маш сайн бүтээлүүд үүсэхэд зайлшгүй чухал хүчин зүйл болдог.

5. Хөгжмийн боловсрол нь хүмүүсийн хоорондын харилцааны менежментэд үзүүлэх нөлөө

Утга зохиолын мастер Толстой “Заримдаа хүмүүс хоорондоо дайсагналцдаггүй ч сэтгэл хөдлөл нь хоорондоо нийцэхгүй тохиолдол байдаг. Гэнэт хөгжим хүн бүрийг аянга цахилгаан шиг холбож, өнгөрсөн саад бэрхшээлийг даван туулж, хүмүүс эв нэгдэл, нөхөрлөлийг мэдэрдэг” (Толстой, 1958) гэж хэлсэн. Хөгжимд суралцахад оюутнууд багаар ажиллах замаар эв нэгдэлтэй, гайхамшигтай дууны эффектийг мэдрэх боломжтой. Дадлага хийх явцад оюутнууд найрал дууны эгшиг, эв нэгдэл, харилцан туслалцааны сайхныг мэдрэх, бусадтай найрсаг харьцах, баяр баясгаланг ойлгохын тулд бусад оюутнуудыг анхааралтай сонсож, тэдний дуу хоолойтой аажмаар зохицдог. Мөн найрал дууны үйл явцад биеийн зарим хэлэмжийг нэмж оруулах боломжтой бөгөөд энэ нь оюутнуудын хамтын ажиллагааны уур амьсгалыг улам өдөөж болох юм. Энэ үйл явцад таагүй харилцаатай оюутнуудын хоорондын харилцаа сайжирсныг олж мэдэх боломжтой.

Дүгнэлт

Хөгжим нь зөвхөн уран сайхны илэрхийлэх хэлбэр биш, юуны түрүүнд хүний оюун санааны хэл, сэтгэл хөдлөл, сэтгэлийн хөдлөлийн хэл, хүн төрөлхтний түгээмэл хэл шинжлэлийн хэл юм.

Энэ нь сэтгэл судлал, хэл шинжлэл, мэдрэл ба тархины шинжлэх ухаан, антропологийн хамгийн сүүлийн үеийн судалгааны үр дүнгээр батлагдсан болно. Хөгжмийн урлаг ба хөгжмийн боловсрол нь хүмүүст сэтгэл хөдлөлийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийн боловсрол, гоо зүйн таашаал өгөх төдийгүй хүний бие бялдар, оюун санааны хөгжилд чухал нөлөө үзүүлдэг байна.

Ховард Гарднер хөгжмийн оюун ухааныг оюун ухааны цогцолбор онолдоо нэг хэсэг хэмээн үздэг. Үнэндээ хөгжмийн оюун ухаан нь мөн чанартаа сэтгэл хөдлөлийн оюун ухаан юм.

Хөгжмийн боловсрол нь бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэхэд нөлөөлдөг төдийгүй хүн өөрийнхөө сэтгэл хөдлөлийг ойлгож, мэдрэхэд нөлөө үзүүлэхээс гадна хүн сэтгэл хөдлөлөө зөв удирдан жолоодосноор хүн хоорондын харилцаа, өөрийгөө идэвхжүүлэхэд нөлөөлдөг байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Bruner and Gordon, C. 1990. "Music, Mood and Marketing." *Journal Of Marketing*, 54.
2. Goleman, Daniel. 1997. *Emotional intelligence*. Shanghai: Shanghai Science and Technology Press.
3. Gabriela Ilie, William Forde Thompson. 2006. "A comparison of acoustic cues in music and speech for three dimensions of affect." *Music Perception*, 23.
4. Jiang, Yu. 1985. "Experiments and discussions on emotions and emotional experiences caused by music." *Educational Science*, 53.
5. Jingjing, Yin. 2010. "Cultivation of children's emotional intelligence through music education." *Art Exploration*, 32-33.
6. Lev Nikolayevich Tolstoy. 1958. *War and Peace*. People's Literature Publishing House.
7. Wedin, L. 1972. "A multidimensional study of perceptual-emotional qualities in music." *Scandinavian Journal of psychology*, 241-257.
8. Weiping, Huang . 2007. "Empirical study on the impact of classical music on college students' emotions." Changsha: Hunan Normal University, 90.

9. Wulanjie. 2012. Recorded interviews with the inheritors of long-tune folk songs. Proceedings of the 4th “Baoyindeliger” Cup Long-Tune Competition and the East Ujimqin Forum on Mongolian Long-Tune Art. China-Uzbekistan Riasta.
10. Cai Yuejian, Pan Xiaofu, Zhuang Zhongchunxiao. 2007. “An empirical study on the impact of music speed and mode on college students’ emotions.” Psychological Science, 196-198.
11. Zhaolan, Meng. 2005. Emotional Psychology. Beijing: Peking University Press.